



САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цээл сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2026/005/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn	Дарга, Тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа
Алтай хот	Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn
2026 он	Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг
	Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn
	Ахлах аудитор: Д.Цэрэнханд
	Утас: 99086371 Цахим хаяг: Tserenkhandd@audit.gov.mn
	Аудитор: Э.Сүнжидмаа
	Утас: 80048599 Цахим хаяг: Sunjidmaae@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82091
Утас: (976) 70 48 34 13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2025.03.24 № 141

танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Цээл сумын Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол Цээл сумын Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доор зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Үүнд:

Орон нутгийн төсвийн орлогын шууд бус орлого 20.0 сая төгрөгөөр, ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого 1.4 сая төгрөгөөр тус тус тасарсан,

Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн харьяа нэгж, байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар залруулагдаагүй 94.9 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 16 дугаар зүйлийн 16.5.2, 41 дүгээр зүйлийн 41.2.1 заалтыг зөрчсөн, Цээл сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын

- 822511000423

2025 оны 09 дугаар сарын 12-ны өдрийн 09 дүгээр тогтоолыг хэрэгжүүлээгүй нь санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинэ спорт заал, 72 хүүхдийн цэцэрлэг ашиглалтад орсон байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд 1,935.8 сая төгрөгийн төсөв баталж, гүйцэтгэлээр 1,567.7 сая төгрөгийг зарцуулж 80.9 хувьтай байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд 12 хөтөлбөр 83 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас 92.0 хувиар дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮДЭХ
АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан (мянган төгрөг)

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,326,343.1	1,338,962.5
2	МӨНГӨН ХӨРӨНГӨ	426,644.2	596,770.6
3	АВЛАГА	126,418.2	112,857.2
4	БАРАА МАТЕРИАЛ	131,445.2	137,865.0
5	НӨӨЦИЙН БАРАА	115,701.4	34,833.4
6	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	526,134.1	456,636.4
7	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,519,894.4	3,570,015.1
8	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,519,894.4	3,570,015.1
9	2.2.02	3,446,598.4	3,496,719.1
10	2.2.03	73,296.0	73,296.0
11	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	4,846,237.6	4,908,977.6
12	НИЙТ ӨР ТӨЛБӨР	7,702.7	37,148.5
13	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	7,702.7	37,148.5
14	1.1.03	7,702.7	37,148.5
15	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,838,534.9	4,871,829.2
16	Засгийн газрын хувь оролцоо	4,838,534.9	4,871,829.2
17	Засгийн газрын оруулсан капитал	334,925.8	334,925.8
18	дүн	4,336,229.2	4,369,523.5
19	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	167,379.9	167,379.9
20	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	4,846,237.6	4,908,977.6

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан (мянган төгрөг)

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	3,906,341.3	2,083,161.4
2	ТАТВАРЫН ОРЛОГО	1,071,681.0	888,492.6
3	Орлогын албан татвар	471,727.1	467,105.5
4	Хувь хүний орлогын албан татвар	490,864.4	504,250.1
5	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(19,137.2)	(37,144.6)
6	Хөрөнгийн албан татвар	283,266.5	212,131.5
7	Бусад татвар, төлбөр, хураамж	316,687.3	209,255.5

8	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,653,584.6	1,194,668.8
9	Тусламжийн орлого	-	427,035.8
10	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,181,075.6	-
11	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,056,736.4	1,573,081.0
12	УРСГАЛ ЗАРДАЛ	2,056,736.4	1,573,081.0
13	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,019,904.3	1,551,740.1
14	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	723,663.5	806,863.6
15	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	90,741.3	101,465.3
16	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	185,367.2	184,652.8
17	Хангамж, бараа материалын зардал	494,870.6	62,828.9
18	Нормативд зардал	1,935.0	720.0
19	Эд хогшил, урсгал засварын зардал	53,031.0	2,238.0
20	Томилолт, зочны зардал	23,538.0	15,390.0
21	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,730.3	3,594.5
22	Бараа үйлчилгээний бусад зардал	440,027.0	373,986.8
23	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	36,832.1	21,340.8
24	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,849,604.8	510,080.4
25	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	579,835.5	476,786.2
26	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	(579,835.5)	(476,786.2)
27	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	1,269,769.2	33,294.2

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (мянган төгрөг)

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

№	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө /өмч
1	2023 оны 12-р сарын 31- нээрх үлдэгдэл	3,588,265.6	3,588,265.6
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(19,500.0)	(19,500.0)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,568,765.6	3,568,765.6
4	Тайлант үеийн үр дүн	1,269,769.2	1,269,769.2
5	2024 оны 12-р сарын 31- нээрх үлдэгдэл	4,838,534.8	4,838,534.8
6	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	4,838,534.8	4,838,534.8
7	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,838,534.8	4,838,534.8
8	Тайлант үеийн үр дүн	33,294.2	33,294.2
9	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,871,829.1	4,871,829.1

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан (мянган төгрөг)

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	2,283,288.6	1,739,865.0
2	ТАТВАРЫН ОРЛОГО	1,071,681.0	888,492.6
3	Орлогын албан татвар	471,727.1	467,105.5
4	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(19,137.2)	(37,144.6)
5	Хөрөнгийн албан татвар	283,266.5	212,131.5
6	Бусад татвар, төлбөр, хураамж	316,687.3	209,255.5
7	Бусад нийтлэг төлбөр, хураамж	6,083.3	4,196.0
8	Газрын төлбөр	310,158.5	203,813.1
9	Байгалийн нөөц ашигласны төлбөр	445.5	1,246.4
10	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	30,532.0	851,372.3
11	Нийтлэг татварын бус орлого	30,532.0	37,001.5
12	Тусламжийн орлого	-	427,035.8
13	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	-	387,334.9
14	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,181,075.6	-
15	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,429,336.4	1,205,390.1
16	УРСГАЛ ЗАРДАЛ	1,429,336.4	1,205,390.1
17	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,392,504.2	1,184,674.3
18	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	723,663.5	806,863.6
19	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	88,912.6	101,465.3
20	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	190,797.5	186,503.4
21	Хангамж, бараа материалын зардал	86,209.7	32,996.0
22	Норматив зардал	1,935.00	540.0
23	Эд хогшил, урсгал засварын зардал	56,906.09	2,098.0
24	Томилолт, зочны зардал	24,418.00	12,044.0
25	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,730.3	3,779.5
26	Бараа үйлчилгээний бусад зардал	212,931.4	38,384.3
27	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	36,832.1	20,715.8
28	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	853,952.1	534,474.9
29	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	782,562.0	364,348.5
30	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	782,562.0	364,348.5
31	Дотоод эх үүсвэрээр	782,562.0	364,348.5
32	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(782,562.0)	(364,348.5)

33	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	71,390.1	170,126.3
34	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	355,254.0	426,644.1
35	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	426,644.1	596,770.5

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (мянган төгрөг)

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

Дансы код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,935,041.70	1,737,838.8	229,853.65	88.1
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,821,337.7	1,706,056.8	115,280.8	93.6
33	Оны эхний үлдэгдэл	251,432.0		251,432.0	-
122005	Аймгаас санхүүжих	425,009.7	425,009.7	0	100.0
11	Татварын болон татварын бус орлого	753,648.6	893,712.2	140,063.6	119.0
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	391,247.4	387,334.9	3,912.5	76.0
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	114,504.00	31,782.0	85,164.5	25.6
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,190.0	18,714.0	(15,081.5)	1,367.4
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	113,314.00	13,068.00	100,246.0	11.5
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,935,841.7	1,567,712.4	368,129.2	81.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,252,713.0	1,206,263.9	46,449.0	96.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,229,989.0	1,185,548.1	44,440.8	96.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	810,411.7	806,863.6	3,548.0	99.6
210101	Үндсэн цалин	433,471.7	428,379.6	5,092.0	98.8
210102	Нэмэгдэл	287,390.0	290,957.3	(3,567.3)	101.2
210103	Унаа хоолны хөнгөлөлт	56,080.0	54,720.0	1,360.0	97.6
210104	Урамшуулал	33,470.0	32,806.6	663.3	98.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	102,335.0	101,465.3	869.6	99.2
210201	Тэтгэврийн даатгал	70,412.0	69,542.3	869.6	98.8
210202	Тэтгэмжийн даатгал	7,980.7	7,980.7	-	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,990.4	3,990.4	-	100.0

210204	Ажилгүйдлийн даатгал	3,990.4	3,990.40	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	15,961.5	15,961.5	-	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	189,209.4	186,503.4	2,705.9	98.6
210301	Гэрэл, цахилгаан	33,948.0	25,551.1	8,396.8	75.3
210302	Түлш, халаалт	151,913.4	157,839.1	(5,925.7)	103.9
210303	Цэвэр, бохир ус	3,348.0	3,113.2	234.8	93.0
2104	Хангамж, бараа материалын зардал	45,778.6	31,499.8	14,278.8	68.8
210401	Бичиг хэрэг	4,620.3	2,921.5	1,698.8	63.2
210402	Тээвэр, шатахуун	31,998.3	22,199.4	9,798.9	69.4
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,560.0	1,364.0	196.0	87.4
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,500.0	2,248.0	2,252.0	50.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,100.0	2,766.90	333.1	89.3
2105	Норматив зардал	810.0	540.0	270.0	66.7
210502	Хоол, хүнс	810.0	540.0	270.0	66.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,000.0	4,998.0	3,002.0	62.5
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,000.0	-	3,000.0	-
210604	Урсгал засвар	5,000.0	4,998.0	2.0	100.0
2107	Томилолт, зочны зардал	15,500.0	12,044.0	3,456.0	77.7
210702	Дотоод албан томилолт	15,500.0	12,044.0	3,456.0	77.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,594.3	3,779.5	814.7	82.3
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,060.0	767.0	293.0	72.4
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,010.0	403.2	606.8	39.9
210803	Даатгалын үйлчилгээ	369.0	369.0	-	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	119.7	119.7	-	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22.0	22.0	-	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,540.0	1,625.0	(85.0)	105.5

210807	Газрын төлбөр	473.6	473.61	(0.0)	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	53,350.0	37,854.4	15,495.6	71.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	47,350.0	33,175.4	14,174.6	70.1
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,000.0	4,679.0	1,321.0	78.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	22,724.0	20,715.8	2,008.1	91.2
2132	Бусад урсгал шилжүүлэг	22,724.0	20,715.8	2,008.1	91.2
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	19,384.0	18,383.8	1,000.1	94.8
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,340.0	2,332.0	1,008.0	69.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	569,814.70	361,448.51	208,366.1	63.4
223001	Бусад хөрөнгө	569,814.70	361,448.51	208,366.1	63.4
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	113,314.0	-	113,314.0	-
230001	Эргэж төлөгдөх зээл	113,314.0	-	113,314.0	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	426,644.1	(426,644.1)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	596,770.5	(596,770.5)	

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан (мянган төгрөг)

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

Дансны код	Дансны нэр, төрөл	Тайлант он
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	2,026.1
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,026.1
350014	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,026.1
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,026.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,026.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,026.1
2104	Хангамж, бараа материалын зардал	1,496.2
210402	Тээвэр, шатахуун	1,376.2
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	120.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	529.9
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	529.9

3.АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Цээл сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 3 тусгай сан, 4 байгууллагын (Сургууль, Соёлын төв, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төв) тогтмол зардал нэгтгэсэн байна.

Аудитаар ЗДТГ-ын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийж “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Хоршоо хөгжүүлэх сан, Байгаль хамгаалах нөхөн сэргээх барьцаа хөрөнгийн сан, Орон нутгийн хөгжлийн сан, Сургууль, Соёлын төв, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төвийн тогтмол зардлыг аудитын түүвэрт хамруулсан

3.1 Аудитаар Засаг даргын Тамгын газрын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил

Аудитаар бүртгэл тайлагналтай холбоотой 26.7 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан 2 алдааг залруулж, 1.2 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож 4.7 сая төгрөгийн 2 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн байна

3.2 Түүвэрт хамрагдсан иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Хоршоо хөгжүүлэх сан, Байгаль хамгаалах нөхөн сэргээх сан, Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил

Аудитаар санхүүгийн тайлангийн бүртгэл, тайлагналыг 96.2 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан 3 алдааг залруулж, 26.7 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 2.2 сая төгрөгийн 1 зөрчлийг арилгах албан шаардлага, 59.9 сая төгрөгийн 1 зөвлөмж хүргүүлсэн байна.

3.3 Төсвийн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын илрүүлэлт:

Аудитаар залруулга хийгдээгүй болно.

Аудитаар нийт 21.7 сая төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг байдлын төвшнөөс бага бөгөөд харьяа байгууллагуудын материаллаг зөрчил 94.9 сая төгрөг байгаа тул шинж чанарыг харгалзан үзэж “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

Илэрсэн зөрчилд 1 албан шаардлага, 21.7 сая төгрөгийн 1 зөвлөмж хүргүүлээ.

3.4 Албан шаардлага

1. Төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар нийт санхүүгийн 94.9 сая төгрөгийн зөрчил илэрснээс 28.1 сая төгрөгийн 2 төлбөрийн акт 6.8 сая төгрөгийн 3 зөрчил арилгах албан шаардлага, 59.9 сая төгрөгийн 1 зөвлөмж өгсөн нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 14.2.5-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах", 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", гэж заасныг зөрчсөн, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Харьяа төсөвт байгууллагуудын үйл ажиллагаанд тавих хяналтын сайжруулж, зөрчлийг арилгах

3.5 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Нэг. Нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой

Илрүүлэлт: Орон нутгийн орлогын төлөвлөгөөг үзэхэд шууд бус орлого 20.3 сая төгрөгөөр, ан амьтны нөөц ашигласны төлбөр 1.5 сая төгрөгөөр тус тус тасарсан нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-т "Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх", Цээл сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 09 дугаар сарын 12-ны өдрийн 09 дүгээр тогтоолд заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Орон нутгийн орлогыг бодит тооцоололд үндэслэн оновчтой төлөвлөж, биелэлтийг хангуулан ажиллах.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг тайлан хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мянган төгрөг)

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн	
							Тоо	Дүн	Тоо	Дүн			
Цээл сумын Засаг даргын нэгтгэсэн тайлан	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Цээл сумын Засаг даргын Тамгын газар	2	26,358.9	1	13,308.9	2	13,050.0	3	26,358.9	-	-	-	-	-
Цээл сумын Орон нутгийн хөгжлийн сан	2	94,322.2	1	15,982.2	1	78,340.0	2	94,322.2	-	-	-	-	-
Цээл сумын Хоршоо хөгжүүлэх сан	1	1,838.7			1	1,838.7	1	1,838.7	-	-	-	-	-
Дүн	5	122,519.8	2.0	29,291.1	4.0	93,228.7	6.0	122,519.8	-	-	-	-	-

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөг)

Байгууллагын нэр	Бүгд	Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс	Түүвэрт	Нийт зөрчил		Үүнээс									
									Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
							Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Цээл сумын Засаг даргын нэгтгэсэн тайлан	1		1	-	-	-	2	21,780.5	-	-	1	-	1	21,780.5	-	-	-	-
Цээл сумын Засаг даргын Тамгын газар	1	1		-	-	-	3	5,993.90	1	1,296.8	2	4,697.1	-	-		-	-	-
Цээл сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	1	-	-	-	-	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Цээл сумын сумын Орон нутгийн хөгжлийн сан	1	-	-	-	-	1	1	59,980.00	-	-	-	-	1	59,980.0	-	-	-	-
Цээл сумын сумын Байгаль хамгаалах нөхөн сэргээх сан	1	-	-	-	-	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Цээл сумын сумын Хоршоо хөгжүүлэх сан	1	-	-	-	-	1	2	28,946.30	1	26,776.60	1	2,169.7	-	-	-	-	-	-
Дүн	6	1	1	-	-	4	8	116,700.70	2	28,073.40	4	6,866.80	2	81,760.50	-	-	-	-